



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/482

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн ИТХ-ын 2019 оны "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 10/06 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Шилмэл мал" дэд хөтөлбөрт малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, баталгаажсан үүлдрийн малыг нутагшуулах, үржүүлэх, үхэр сүргийн махан ашиг шимийг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхээр Сэлэнгэ аймгаас "Герефорд", Булган аймгаас "Сэлэнгэ" үүлдрийн өсвөр үхрийг тээвэрлэх зардалд зарцуулах 10000.0 мянган төгрөг /арван сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 10.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.20-д баталсан "Шилмэл мал" хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус, тус зөвшөөрсүгэй.

3. Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж өсвөр үхрийг хүлээн авч, тээвэрлэх ажлыг зохион байгуулан, ашиглагчид хувиарлан хүргүүлэх, данс бүртгэлд тусгах ажлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэн ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/, мал эмнэлгийн үзлэг, урьдчилан сэргийлэх ажиллагааг тухай бүр хийж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/, маллагч иргэнтэй гэрээ хийж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт тус, тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Б.ДҮГЭРЖАВ



Зах А/482 Ч

02 02143

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/482 дугаар захирамжийн хавсралт



ГЕРЕФОРД, СЭЛЭНГЭ ҮҮЛДРИЙН ҮХЭР ТЭЭВЭРЛЭХ ЗАРДАЛ

ДД	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1	Тээврийн зардал				6720.0
	1.1.Тээврийн хөлс	тн	7	600000.00	4200.0
	1.2. Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймаг Зүүнбүрэн сум, Булган аймаг Сэлэнгэ сум хүртэлх 500 км-т зарцуулах шатахуун	2	200	1800.00	360.0
	1.3. Сэлэнгэ аймаг Зүүнбүрэн сум, Булган аймаг Сэлэнгэ сумаас Ховд аймаг хүртэл 2000 км-т зарцуулах шатахуун	л	1200	1800.00	2160.0
2	Ажлын хэсгийн зардал				2656.0
	2.1.Томилолтын зардал /мал зүйч-2, малын эмч-1, жолооч-1/	Хүн/өдөр	40	36000.00	1440.0
	2.2.Ажлын хэсгийн машины шатахууны зардал /Нийт 4000 км/	л	760	1600.00	1216.0
3	Бусад зардал				624.0
	3.1.Өвс, тэжээл	боодол	25	10000.00	250.0
	3.2.Эм тариа боох материал	ком	2	140000.00	280.0
	3.3.Бусад зардал				94.0
	Нийт дүн /1+2+3/				10000.0

-oOo-